

КАЗАХСТАНЫ СЭТГҮҮЛ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Хуандаг Шамахайулы*

* Казахстаны Евразийн их сургуулийн доцент, хэл бичгийн ухааны доктор (Ph.D).

Түлхүүр үг: тоталитар дэглэм, мэдээллийн шинэ сэтгэхүй, мэдээллийн шинэ орон зай, мэдээллийн чөлөөт урсгал.

Тоталитар дэглэм унаж, ЗХУ задарсан нь холбооны улсууд тусгаар тогтнолоо тунхаглан зарлахад хүргэж, нийгмийн бүх салбарт, түүний дотор хэвлэл мэдээллийн зах зээлд томоохон өөрчлөлт гарахад нөлөөлсөн билээ. Коммунист үзэл суртлын орон зайг олон ургальч үзэл, ил тод байдал эзэлж, цензурын оронд ХМХ-ийн бие даасан байдал хүчтэй нэвтрэх эхлэл тавигдав. Энэ үйл явцад Казахстан Дундад Азийн орнуудын дотор тэргүүн эгнээнд явж байна гэж хэлж болно.

Гэхдээ мэдээллийн шинэ сэтгэхүйг төлөвшүүлэх үйл явц амар хялбар бус, багагүй саад бэрхшээлтэй тулгарч байгааг Казахстаны сэтгүүл зүйн өнөөгийн

дүр төрх тодорхой харуулж байна. Хуучин байр сууриа, чиг баримжаагаа нэгэнт алдсан шинэ тутам улс орнууд мэдээллийн зах зээлийг оновчтой зохицуулах, чөлөөт хэвлэлийг жинхэнэ утгаараа бий болгох, мэдээллийн хэрэгслийн бие даасан байдлыг хангах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, сэтгүүлч боловсон хүчнээр хангах талаар удаан боловч урагшлах хандлага ажиглагдаж байна. Ахар богино хугацаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо эрс нэмэгдэж, өнөөдөр албан ёсоор бүртгүүлсэн 7000 гаруй ХМХ-ийн 2500 гаруй нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн 80 хувь нь төр засгаас хараат бус байгаа нь хэвлэл мэдээллийн бие даасан байдал бодит үзэгдэл болсны илрэл мөн. Тэдний дотор "Алтын Орда" ("Алтан Орд"), "Казахстан", "Туркестан", "Жаз казах" ("Залуу казах"), "Жас Алаш" ("Залуу Алаш") зэрэг бие

даасан чөлөөт хэвлэл сөрөг байр суурийг баримтлалдаг бөгөөд олон нийтийн анхаарлыг илүү их татдаг. Мөн тогтмол хэвлэлийн хамт бие даасан теле, радиосувгийн тоо ч нэмэгдэж, эрчимтэй хөгжих хандлага ажиглагдаж байгаа боловч одоохондоо тогтмол хэвлэлтэй өрсөлдөх төвшинд хараахан хүрээгүй байна.

Казахстан дахь мэдээллийн чөлөөт урсгалын зарчим нь юуны өмнө ХМХ-үүдийн агуулгыг бус гадна талыг хөндөх болов. Борооны дараах мөөг шиг олширсон тогтмол хэвлэл, дараа нь радио, телевиз, сүүлд гадаад улс орнуудтай хамтарсан

(турк-казах, орос-казах, казах-туркийн хамтарсан) ХМХ-үүд бий болж, олон нийтийн мэдээдэл харилцааны шинэ зах зээлийг бүрдүүлсэн бөгөөд энэ нь өнөөдөр хэд хэдэн үе шатыг дамжин хөгжиж ирсэн түүхтэй юм. Эхний үе шат нь өөрчлөн байгуулалтын ачаар олж авсан эрх чөлөөний далбаан дор ХМХ-үүд нэлээд хавтгайрах, тооны араас хэт хөөцөлдөж, нийтлэл нэвтрүүлгийн агуулгыг үл хайхрах хандлагатай байлаа.

«

Казахстаны хэвлэл мэдээллийн салбар дахь хувьсгалт өөрчлөлт нь өмнө нь Дорнод Европын орнуудад явагдсан үйл явцтай нэлээд төстэй. Эхний үед тэр орнуудын нэгэн адил Казахстанд ХМХ улс төрийн амьдралыг өөрчлөн шинэчлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэв. Янз бүрийн үзэл бодлын индэр, олон нийтийн дуу хоолой болох замаар ХМХ улс төрийн шинэ нам, хөдөлгөөнүүд үүсэж бий болоход хүчтэй нөлөө үзүүлсэн юм.

»

Хоёр дахь үе шат нь удирдан чиглүүлэгч ЗХУКН тэргүүтэй нэг намын үзэл суртал сүйрч, олон намын систем нэвтэрсэн нь ХМХ-үүд урьд өмнө үзэгдэж байгаагүй төвшинд идэвхжиж, эрчимтэй алхам хийхэд нөлөөлсөн. Хэвлэн нийтлэгчид, сэтгүүлчид олон жилийн турш ил гаргаж

чадаагүй өөрсдийн үзэл бодол, дуу хоолойг илэрхийлэх зорилгоор ХМХ-үүдийн өнгө төрх, бодлого чиглэлийг өөрчлөхийн төлөө хүчин зүтгэх болов. Үүний үр дүнд урьд өмнө байгаагүй цоо шинэ чиглэл, хэв маягийн сонин хэвлэл, радио, телевизийн суваг Казахстаны мэдээллийн зах зээлд

өөрийн гэсэн байрыг эзэлсэн билээ.

Казахстаны хэвлэл мэдээллийн салбар дахь хувьсгалт өөрчлөлт нь өмнө нь Дорнод Европын орнуудад явагдсан үйл явцтай нэлээд төстэй гэж хэлж болно. Эхний үед тэр орнуудын нэгэн адил Казахстанд ХМХ улс төрийн амьдралыг өөрчлөн шинэчлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэв. Янз бүрийн үзэл бодлын индэр, олон нийтийн дуу хоолой болох замаар ХМХ улс төрийн шинэ нам,

хөдөлгөөнүүд үүсэж бий болоход хүчтэй нөлөө үзүүлсэн юм. Энэ бол ХМХ-үүд зах зээлийн хөгжлийн гурав дахь үе байв. Ийм үйл явц Унгар, Польш, Чех зэрэг улс оронд янз бүрийн төвшинд, тодорхой хэмжээгээр явагдсан юм. Энэ бүхэн нь Казахстанд чөлөөт хэвлэл бий болоход эерэг нөлөө үзүүлсэн боловч ийм хандлага, үйл явц, эрх чөлөө цаашид урьдын адил эрчимтэй, тогтвортой явж чадсангүй. Казахстаны нэрт эрдэмтэн, профессор С.Козыбаевын үгээр хэлбэл: "Эрх чөлөө удаан үргэлжилсэнгүй. Бүх нийтийг хамарсан давалгаа эрчимтэй эхлэв. Намуудын болон улс төрийн хөдөлгөөнүүдийн Засгийн эрхийн төлөө тэмцэл ширүүсэв. Зах зээл өөрийн нөхцөл, шаардлагыг тавьж эхлэв. Төр засгийн татаас зогсож, хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, цаасны болон шуудан холбооны үнэ эрс өсөн нэмэгдэв. Хүчтэй, заримдаа бүр "харгис" шинжтэй өрсөлдөөн эхэлж, төрийн болон төрийн бус сонин хэвлэл, телевизугуудын хоорондох мэдээллийн зөрчил газар авсан"¹ юм. Тухайлбал, Казахстаны нөлөө бүхий хэвлэл "Караван" ("Тэмээн жин"), "Казахстанская правда" ("Казахстаны үнэн"), "Вечерний Алматы" ("Алматын үдэш") болон зарим телесуваг аливаа асуудлын талаар төр засагт хандах байр сууриа тайлбарлаж, эв нэгдлийн ашиг сонирхлын толь болж

байв. Казахстаны тогтмол хэвлэл заримдаа аар саар зүйлээр хөөцөлдөж, үндэсний ухамсрыг булингартуулах оролдлого хийж эхэлсэн нь хэвлэлийн эрх чөлөөг өөрсдийн ашиг сонирхлын зорилгод ашиглаж буйн илрэл байлаа. Олон зуун хот айлын хэнд ч үл мэдэх "баатруудыг" болон одоо амьд сэрүүн байгаа зарим хүнийг учир зүггүй сурталчилж, тэнгэрт тултал магтан дуулж, зарим сэтгүүлч эрх мэдэлтнүүдийн хэрүүл маргаан, зөрчил тэмцлийн объект болон хувирсан билээ. Энэ бүхэн нь ХМХ-үүдийн хөгжлийн шинэ эргэлтийн эхлэл байсан бөгөөд үүний үр дүнд олон сонин хэвлэл үйл ажиллагаагаа өөрчлөн шинэчилж, зарим нь бүрмөсөн зогсоож, төрийн мэдлийн сонин, сэтгүүлүүдийн хэвлэгдэх хувь болон захиалагчдын тоо эрс багасч, давтамж нь цөөрсөн нь олон арван сэтгүүлч сэтгүүл зүйн салбараас шахагдахад хүргэсэн юм.

Өөрсдийн урьд барьж байсан бодлого чиглэлээс татгалзсан сонин хэвлэлүүд зах зээлийн нийгмийн шинэ нөхцөл байдал, цаг үеийн шаардлагад дасан зохицож, үйл ажиллагаагаа өөрчлөн шинэчлэх идэвхтэй алхам хийж эхлэв. ХМХ-ийн тогтворгүй байдал нь сэтгүүлч боловсон хүчний бодлогод хүчтэй нөлөө үзүүлсэн бөгөөд шинэ нөхцөл байдалд шинээр сэтгэж, шинэ арга барилаар ажиллах

бие даасан, чөлөөт хэвлэлийн боловсон хүчин хурцаар шаардагдах болов. Сүүлийн жилүүдэд сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулийн тоо 26-д хүрч, ХМХ-ийн боловсон хүчин бэлтгэх сонирхол эрс нэмэгдсэн нь чанаргүй, орчин үеийн сэтгүүл зүйн шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй ажилтан олшироход нөлөөлж байна. Материаллаг баазгүй, багшлах боловсон хүчингүй бараг хоосон шахуу газарт сэтгүүл зүйн олон арван салбар, факультетыг нээсэн нь тэхдээ тэргүй хүнд нөхцөлд байгаа сэтгүүл зүйн нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн гэж хэлж болно. Гэхдээ цаг үеийн шалгуур, зах зээлийн хатуу зарчим аливаа зүйлийг өөрт нь тохирсон байранд тавьж эхэлсэн нь сэтгүүлч боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулиудыг ч тойрч өнгөрсөнгүй.

Зах зээлийн аливаа ололт амжилт, дутагдал доголдол масс-медиагийн агуулгатай шууд холбоотой гэдгийг хэлэх хэрэгтэй. Тоталитар нийгмийн ХМХ-үүдийн саарал магтаал, хоосон мэдээлэл, ядуу зүдүү амьдрал ахуйг ямар ч учир утгагүй, бодлогогүй сурталчилсан нь сэтгүүл зүйн нэр хүндийг гутаах, хүнлэг бус болгоход нөлөөлсөн билээ. Энэ бол тухайн үеийн сэтгүүл зүйн хамгийн ноцтой, хамгийн бүдүүлэг алдаа байсан бөгөөд ялангуяа залуу үеийнхнийг

хүнлэг бус, өрөвдөх сэтгэлгүй болгон хүмүүжүүлэхэд нөлөөлсөн юм. Өнөөдөр энэ нь бүхэл бүтэн нийгэмд халдварласныг төвөггүй ажиглаж болно.

Мэдээллийн зах зээл ХМХ-ийн системийг, тэдний бүтцийг цаг алдалгүй өөрчлөхийг шаардаж байгаа бөгөөд энэ нь сэтгүүл зүйн ирээдүйг тодорхойлогч шийдвэрлэх хүчин зүйл болох нь тодорхой юм. Олон нийтийн санаа бодлын хүчтэй зэвсэг болох ХМХ хэний гарт байх вэ гэдэг асуулт зөвхөн төр засгийн монополь эрхийг хязгаарлах, чөлөөт хэвлэлийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх тухай асуулт төдий бус Казахстаны сэтгүүл зүйн ирээдүйн тухай асуулт учир зарчмын чухал ач холбогдолтой гэдэг нь ойлгомжтой юм.

Өнөөдөр Казахстаны радио, телевиз эрчимтэй хөгжих замд дөнгөж хөл тавьж эхэлсэн учир одоохондоо сонин, хэвлэлтэй өрсөлдөх төвшинд хараахан хүрээгүй байна. Гэхдээ энэ бол цаг хугацааны асуудал юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн, юуны өмнө төрийн мэдэлд байгаа мэдээллийн хэрэгслүүдэд хяналт тавихын төлөө тэмцэл бол эцсийн эцэст эрх мэдлийн төлөө тэмцэл мөн. Сүүлийн жилүүдэд энэ тэмцэл улам эрчимтэй явагдах болсон. Намын лидерүүд, төр засгийн эрх мэдэлтнүүд аливаа хэвлэл мэдээллийн байгууллагыг өөрийн үзэл, суртлын зэвсэг болгохын

төлөө, эрх ашиг, үзэл бодлоо хамгаалагч, бодлогоо сурталчлах индэр болгохын төлөө хүчин зүтгэж байна. Ийм ширүүн өрсөлдөөний үед хэвлэлийн эрх чөлөөний асуудлыг хэн оновчтой, хэн зөв тавих болно, тэр хүн хэвлэл мэдээллийн зах зээлд өөрийн байр суурийг баттай эзэлж чадах болно. Гэхдээ энэ бол өнөө маргаашдаа тийм амархан шийдэгдэх асуудал биш гэдгийг Казахстаны сэтгүүл зүйн хөгжлийн өнөөгийн дүр төрх тодорхой харуулж байна.

Казахстанд ОНМХ-ийн жам ёсны монопольчлол ирэх болов уу? Европын хуучин социалист орон болох Унгар, Польш, Чехийн мэдээллийн зах зээлийн нэгэн адил гадаадын хэвлэл мэдээллийн томоохон концернүүд Казахстанд орж ирэх сонирхол байгаа юу? Өнөөдөр Төв Европын хэвлэл мэдээллийн зах зээлийн тал хувь нь гаададын хөрөнгө оруулагчдын мэдэлд байгааг бид мэднэ. Дэлхий дахинд алдартай Херст, Шпрингер, Бертельсман, Маркарын концернүүд хуучин коммунист намуудын шилдэг хэвлэлүүдийг, өдөр тутмын томоохон сонинуудыг, бас орон нутгийн зарим сонин, сэтгүүлийг аль хэдийд худалдан авчээ.

Өнөөдөр ийм үзэгдэл Казахстаны хэвлэл мэдээллийн зах зээлд хүчтэй нэвтэрч чадаагүй ч, гадаадын хэвлэл мэдээллийн нөлөө тодорхой хэмжээгээр

ажиглагдаж эхэлсэн. Энэ бол турк-казахын хамтарсан сонин, казах-оросын хамтарсан хэвлэлүүд, казах-турэгийн хамтарсан телевизийн суваг юм. Сүүлийн жилүүдэд хувь нийлүүлсэн "Кара-ван" нийгэмлэг хэд хэдэн сонин хэвлэлийг зэрэг гаргаж, тус улсын мэдээллийн зах зээлд өөрийн монопольчлолыг тогтоохын тулд нэлээд идэвхтэй ажиллаж байна. Гэхдээ энэ бүхэн зөвхөн эхлэл төдий байгааг хэлэх хэрэгтэй. Өнөөдөр зарим бие даасан чөлөөт сонин хэвлэл олон нийтийн санаа бодолд төрийн мэдлийн болон томоохон улс төрийн намын хэвлэлүүдээс илүү хүчтэй нөлөөлж байгааг тодорхой ажиглаж болно. Өдрөөс өдөрт бие даасан ХМХ-үүдийн тоо нэмэгдэж, нийт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн 80 хувь нь төрийн бус байгаа нь чөлөөт сэтгүүл зүйн тухай өөдрөг сэтгэгдэл төрүүлж байна. Гэхдээ энэ бол зөвхөн тоон үзүүлэлт бөгөөд ХМХ-үүдийн үйл ажиллагаа, нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад төрийн зүгээс болон улс төрийн, бизнесийн бүлэглэлүүдийн зүгээс үзүүлж буй шууд ба дам дарамт шахалтыг харгалзан үзвэл арай өөр дүр зураг бууна. Энэ талаар сэтгүүлч Олег Панфилов "Төр засаг ба хэвлэл мэдээлэл" өгүүлэлдээ: "Одоогоос хэдэн жилийн өмнө, бүр тодруулж хэлбэл, 90-ээд оны эцэс хүртэл Казахстан хуучин ЗХУ-ын

бүрэлдэхүүнд байсан орнуудын дотор хараат бус хэвлэл мэдээллийг бүрдүүлэхийн төлөө хүчин зүтгэж буй орнуудын тоонд багтаж байсан. Энд ТУХН-ийн орнуудын дотор анх удаа "Караван" нэртэй олон нүүртэй, өнгөт сэтгүүл гарч, төрийн мэдлийн радио, телевизээс илүү их нэр хүндтэй хэд хэдэн радио, телестанци ажиллаж байв. 1996 оны сүүлчээр засгийн газар ХМХ-үүдийн дунд нэвтрүүлгийн долгион ашиглах тендер зарлаж, түүнд оролцох байгууллагаас хэдэн зуун мянган доллар нэхэж, бие даасан радио, телекомпанийн хувьд шударга бус шаардлага тавив.

Үүний үр дүнд олон арван радио, телевиз хаалгаа барьж, Ерөнхийлөгчийн охин Даригагийн толгойлсон төрийн мэдлийн "Хабар" ("Мэдээ") холдинг тус улсын мэдээллийн зах зээлд дангаараа ноёрхох болсон. "Караван"-ы эзэн Борис Геллер одоо ОХУ-д амьдарч байна. Сөрөг байр суурийг баримталдаг "ХХI зуун", "Цэрэг" зэрэг сонин бүрмөсөн хаагдсан. Казахстаны бие даасан хэвлэл мэдээллийнхэн зодуулах, баривчлагдах, эрүүгийн хэрэгт татагдах, эрх чөлөөгөө

хасуулах, айлган сүрдүүлэх, хяналт тавих зэрэг дарамт шахалтын бүхий төрөл, хэлбэрийг амссаар байна. Манай орны Хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал Белорусси, Узбекистаны хэмжээнд хүрсэн гэж хэлж болно" гэж тэмдэглэжээ.

Мөн Олон улсын хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах "Отдел СОС" сангийн ерөнхийлөгч Тамара Калеева: "Сүүлийн үед Казахстаны нийт ОНМХ-ийн 80 хувь нь төрийн бус гэж ярьж, бичдэг боллоо. Төрийн бус гэдэг нь бие даасан чөлөөт хэвлэл гэсэн үг биш юм. Хэрэв албан ёсны баримт

«

Өнөөдөр зарим бие даасан чөлөөт сонин хэвлэл олон нийтийн санаа бодолд төрийн мэдлийн болон томоохон улс төрийн намын хэвлэлүүдээс илүү хүчтэй болоолж байгааг тодорхой ажиглаж болно. Өдрөөс өдөрт бие даасан ХМХ-үүдийн тоо нэмэгдэж, нийт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн 80 хувь нь төрийн бус байгаа нь чөлөөт сэтгүүл зүйн тухай өөдрөг сэтгэгдэл төрүүлж байна.

»

бичиг, илтгэл, тайлан зэргээс үзвэл бүх юм сайн сайхан харагдана. ОНМХ-ийн тоо өссөн, сонин сэтгүүлийн хэвлэгдэх хувь нь нэмэгдсэн, бүгд бие даасан, бүгд чөлөөтэй юм шиг. Үнэн хэрэг дээрээ бүгд эсрэгээр. Энэ оны хагас жил гэхэд арваад радио, телестанци, мөн сөрөг чиглэлийг барьдаг сонин хэвлэлийн ганц хоёроос бусад нь хаагдсан. Өнөөдөр Казахстанд хэвлэлийн эрх чөлөө туйлын хүнд, үнэхээр хэцүү байна. Миний бодлоор хамгийн ноцтой юм бол бие

даасан, чөлөөт хэвлэл руу чиглэгдсэн улс төрийн, эдийн засгийн, гэмт хэргийн шинжтэй шахалт дарамт бус, нийт сэтгүүлчдийн дунд бодитой нүүрлэж буй айдас хүйдэс, эрс өсөн нэмэгдэж буй сэтгүүлчийн өөрийн хяналт юм. Энэ бол хамгийн аймшигтай, хамгийн ноцтой зүйл мөн”² гэж Казахстаны хэвлэл мэдээллийн өнөөгийн дүр төрхийн талаар өгүүлжээ.

Зөвхөн нийслэл болон томоохон хотуудад төдийгүй орон нутагт ч сөрөг чиглэлийн ХМХ-үүдийн сэтгүүлчдийг янз бүрийн аргаар дарамтлах, мэдээлэл цуглуулахад саад хийх явдал газар авсан гэж хэлж болно. Ганц жишээ дурдахад Алматад зохиогдсон “Хүний эрхийн асуудлыг ХМХ-д тусгах нь” сэдэвт семинарт оролцох сэтгүүлч Сагат Жүсипт Кызыл-Орда мужийн эрх мэдэлтнүүд яаж саад хийснийг хэлж болно. Тэд Сагатад билет худалдахгүй байх, семинарт оролцуулахгүй байхын тулд чадах бүхнийг хийжээ. Галт тэргийн тасалбар дууссан, онгоцны ачааны даац хэтэрсэн, суусан автобус нь эвдэрсэн, хөлсний тэргийг замын цагдаа явуулаагүй гэх зэрэг түмэн бэрхшээлийг туулж байж арай гэж Алматад ирсэн нь Казахстанд хэвлэлийн эрх чөлөө ямар байгааг харуулах тодорхой баримт мөн.

Казахстаны Соёл, мэдээллийн яамны нийт ХМХ-ийн 80 хувь нь төрийн бус

гэсэн тоо баримтыг хүлээн зөвшөөрч болно. Гэхдээ энэ нь улс төр, бизнесийн томоохон бүлэглэлүүдийн эрх мэдэлд байгаа, өөрөөр хэлбэл, төрийн мэдлээс гараад эрх мэдэлтэн, хөрөнгө мөнгөтэй хүмүүсийн мэдэлд шилжсэн ХМХ гэсэн үг. Казахстанд томоохон бизнесийг төр засагтай нягт харилцаа холбоогүйгээр хийж болохгүй гэдгийг бүгд мэднэ. Тиймээс энэхүү төрийн бус ХМХ-үүд гэдэг нь үнэн хэрэг дээрээ төрийн хяналтанд, заримдаа төрийн ХМХ-үүдээс илүү хатуу хяналтанд байдаг гэж ойлгож болно. Орон нутагт байдал улам хүндэрсээр байна. Павлодард бие даасан бүх ХМХ-үүдийг хаасан, Орон нутгийн эрх мэдэлтнүүд бүгдийг хянадаг. Сэтгүүлчид ямар ч эрх мэдэлгүй бөгөөд тэдний эрх чөлөөг XIX зууны үеийн Оросын хамжлагат тариачдын эрх чөлөөтэй адилхан гэж ойлгож болно. Астана, Алмата зэрэг томоохон хотуудын хувьд нөхцөл байдал арай өөр юм. Энд олон ХМХ үйл ажиллагаа явуулдаг, бизнес-эдийн засгийн бүлэглэл ихтэй, тэд өөрсдийн хэвлэл мэдээллийн салбарт ахиухан хөрөнгө оруулах боломжтой.

Өөр нэг чухал асуудал бол манай сэтгүүлчид өөрийгөө хамгаалж чадахгүй, бас хамгаалах арга ухаанд суралцаагүй явдал мөн. Хүчээ нэгтгэж, хамтран ажиллаж чадахгүй байна. Энэ бол төр

засгийг дураараа аашлах, санасан бүхнийг хийх боломж олгохын зэрэгцээ сэтгүүл зүйг, тэр тусмаа чөлөөт хэвлэлийг үл тоомсорлох нөхцлийг бүрдүүлж байгаа гол хүчин зүйл мөн. Нөгөө талаар сэтгүүлчид маш ядуу, цалин багатай байгаа нь худалдагдах, хэн нэгний “бууны нохой” болох боломж өгч байна.

Сүүлийн жилүүдэд Казахстанд улс төрийн дэглэм улам чангарч, нэг гэр бүл дангаараа ноёрхох явдал хэмжээнээс хэтэрсэнийг сэтгүүлчид шүүмжилдэг боллоо. Үүнд үнэний хувь бий. Хамгийн гол нь сэтгүүлчдийн ухамсарт өөрчлөлт гаргах замаар чөлөөт хэвлэлийн үнэ цэнэ, ач холбогдлыг ард түмэнд ойлгуулах шаардлагатай. Үүнд сэтгүүлчдийн мэргэжлийн мэдлэг, чадвар, туршлага онцгой үүрэгтэй. Харамсалтай нь Казахстаны сэтгүүлчдийн ур чадвар, аливаа шинэ зүйлийг мэдрэх, сэтгэх чадвар нь сул байна. Энэ бол чөлөөт хэвлэлийг хөгжүүлэхэд чөдөр тушаа болж буй бас нэг шалтгаан юм. Мөн сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд ч сэтгүүлч уран бүтээлчдийн эрх ашгийг хамгаалах, дэмжих, туслах талаар идэвх санаачлагүй байна. Нэмж хэлэх өөр нэг чухал зүйл бол Казахстанд хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин хараахан бүрдээгүй, үйлчилж буй хууль эрхийн актуудыг

боловсронгуй болгох шаардлагатай. Гэхдээ сүүлийн жилүүдэд эрх мэдэлтнүүд, төр засгийн түшмэлүүд бие даасан ХМХ-үүдээс айж эмээдэг нь тодорхой болж, тэднийг нухчин дарахын тулд янз бүрийн арга сүвэгчилдэг болсон нь тус орны сэтгүүл зүйд өөдрөг үзлээр хандах сэтгэгдэл төрүүлж байна. Энэ бол ямар ч байсан чөлөөт хэвлэл төр засгийн удирдлагад нөлөөлж чаддаг, бахь байдгаараа ямар ч хөдөлгөөнгүй оршдог хүнд суртлын хүрээнийхнийг хөдөлгөж чадаж буйн илрэл юм. Хэдийгээр Казахстан Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний хорооны 2007 оны тайланд дэлхийн чөлөөт хэвлэлгүй 63 орны тэргүүн эгнээнд явж байгаа боловч бие даасан чөлөөт ХМХ хөгжих, сэтгүүлч уран бүтээлчид хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэх, хүчээ нэгтгэх хандлага ажиглагдаж байна³.

Ишлэл

¹ Козыбаев С. Свобода на рынке прессы // “Казахстанская правда”. 1996.03.05.

² Есдаулетов А. О. 2006. Совершенствовать “индустриальную модель” в подготовке журналистских кадров // “Из истории отечественной журналистики”. №11.

³ www.freedom house.org.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Бегимтаева Р.* 2006. Информационное пространство Казахстана. // "История отечественной журналистики". №6.
2. *Коченов В. Г.* 2006. Журналистика Астаны: проблемы роста // "Из истории отечественной журналистики". №11.
3. *Козыбаев С.* Свобода на рынке прессы // "Казахстанская правда". 1996.03.05.
4. *Полетаев Э.* 2003. Международная журналистика: навигатор для авторов из Центральной Азии. Алматы.
5. www.freedomhouse.org

Резюме

В статье анализируются современное состояние независимой прессы и осо-

бенности формирования свободной печати в Республике Казахстан. Автор, опираясь на примеры и факты из СМИ Казахстана, показывает трудности, встречающиеся в развитии независимой журналистики. Автор статьи делает вывод о том, что принцип свободного потока информации в Казахстане застронул прежде всего внешние стороны, появились десятки независимых СМИ, возник новый рынок средств массовой коммуникации, прошедший на сегодняшний момент несколько этапов. По мнению автора, Казахстан в области революционного взрыва в средствах массовой информации проходит ту фазу, которая ранее наблюдалась в восточно-европейских странах.